

Хариу тодруулга хүргүүлэх тухай

2020.03.16

Булган аймгийн Орон нутгийн өмчийн газраас зарласан Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, /75 ор Гурванбулаг сум/-ийн ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах /БСШУСЯ/202001323/ дугаар бүхий тендер шалгаруулалтанд оролцохыг сонирхогч "Баатар шүтээн уул" ХХК тус тендер шалгаруулалтын машин механизмтай холбоотой тодруулга хүссэн тул тодруулгын хариуг хүргүүлж байна.

Энэ тодруулга нь тус тендерт оролцохыг сонирхсон бусад этгээдүүдэд нэгэн адил хамаарна.

**ТӨӨЗ 5.3 (в).** Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмуудыг ажлын төсөвт тусгагдсаны дагуу доорх хүснэгтэнд зааснаар ирүүлэхийг анхаарна уу.

Д/Д	Машин тоног төхөөрөмжийн нэр	Хүчин чадал	Тоо ширхэг	Эзэмшил
1	Бульдозер	90 морины хүчин чадалтай	1	
2	Эксоватор	1 м3	1	
3	Гинжит кран	16 тонн хүртэл	1	
4	Авто кран	5 тонн	1	
5	Авто кран	10 тн	1	
	Ачааны авто машин		1	
6	Хийн индүү	25 тонн		

Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмуудын жагсаалт болон техник хэрэгслийн гэрчилгээний эх хувиас хийсэн хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ.

2. Түрээсээр ашиглах техник хэрэгслийн түрээсийн гэрээ, техник хэрэгслийн гэрчилгээний эх хувиас хийсэн хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ. Түрээсийн гэрээг зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх бөгөөд гэрээний хугацаа болон бусад асуудлыг тодорхой тусгасан байх.

3. Дээрх хүснэгтэд байгаа гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмуудын 50-аас доошгүй хувь нь өөрийн эзэмшлийнх байх шаардлагатай.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-т заасан хүсэлтийн хуулбарыг түүнд өгсөн хариу тодруулга, нэмэлт мэдээллийн хамт тендерийн баримт бичиг худалдан авсан бүх сонирхогчдод нэгэн зэрэг бичгээр илгээх бөгөөд уг бичгийг шуудангийн байгууллагад хүлээлгэн өгснөөр, эсхүл худалдан авах ажиллагааны цахим системд нийтэлснээр хариу тодруулга, нэмэлт мэдээллийг хүргүүлсэнд тооцно.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА

Б.ЭРДЭНЭБААТАР